



Уурхайн Талбарын Үнэлгээний Хэрэгсэл

Уурхайн талбарын	<input type="text"/>
Компанийн нэр:	<input type="text"/>
Байршил:	<input type="text"/>
Он сар өдөр:	<input type="text"/>

01 Орон Нутгийн Ажил Эрхлэлт		
	Үгүй	Тийм
Энэ уурхайг ажиллуулахдаа компани нь:		
а. Уурхайн нөлөөлөлд өртөж буй орон нутгаас элсүүлсэн ажилчдынхаа тоог олон нийтэд ил тод мэдээлдэг эсэх?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
б. Туслан гүйцэтгэгч, гэрээт компаниудынхаа уурхайн нөлөөлөлд өртөж буй орон нутгаас элсүүлсэн ажилчдын тоог олон нийтэд ил тод мэдээлдэг эсэх?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
в. Компанийн өөрийн болон туслан гүйцэтгэгч, гэрээт компаниудын уурхайн нөлөөлөлд өртөж буй орон нутгаас элсүүлсэн эмэгтэй ажилчдын тоог олон нийтэд ил тод мэдээлдэг эсэх?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
г. Компанийн өөрийн болон туслан гүйцэтгэгч, гэрээт компаниудын уурхайн нөлөөлөлд өртөж буй орон нутгаас элсүүлсэн ажилчдаас ахлах түвшинд тушаал дэвшсэн ажилчдын тоог олон нийтэд ил тод мэдээлдэг эсэх?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

**02 Орон Нутгийн Худалдан Авалт**

Энэ уурхайг ажиллуулахдаа компани нь:		Үгүй	Тийм
а.	Орон нутгаас уурхайд нийлүүлсэн бараа үйлчилгээнд зарцуулсан зардлынхаа мөнгөн дүнг олон нийтэд мэдээлдэг эсэх?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
б.	Орон нутгаас нийлүүлсэн бараа үйлчилгээний төрөл зүйлийн талаар олон нийтэд мэдээлдэг эсэх?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
в.	Орон нутгаас бараа үйлчилгээ худалдан авах хөтөлбөр бэлтгэн батлахдаа уурхайн нөлөөлөлд өртөж буй орон нутгийн иргэдийг хамруулдаг эсэх?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
г.	Уурхайн нөлөөлөлд өртөж буй орон нутгийн эмэгтэйчүүдийг ханган нийлүүлэлтийг дэмжсэн хөтөлбөрүүддээ идэвхтэй хамруулдаг эсэх?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

03 Агаарын Чанар

Энэ уурхайг ажиллуулахдаа компани нь:		Үгүй	Тийм
а.	Уурхай орчмын агаарын чанарыг тогтмол хэмжин үр дүнг тухайн хэмжилтийн цэг бүрээр олон нийтэд ил тод болгодог эсэх?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
б.	Агаарын чанар хаана, хэзээ аюулгүй байдлын зөвшөөрсөн хэмжээнээс доогуур түвшинд хүрсэн талаар онцгойлон мэдээлдэг эсэх?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
в.	Агаарын чанарын талаарх шийдвэр гаргах явцдаа уурхайн нөлөөлөлд өртөж буй орон нутгийн иргэдийг оролцуулдаг эсэх?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
г.	Агаарын чанарын талаарх шийдвэр гаргах явцдаа уурхайн нөлөөлөлд өртөж буй орон нутгийн эмэгтэйчүүдийг идэвхтэй оролцуулдаг эсэх?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>



04 Усны Чанар		
Энэ уурхайг ажиллуулахдаа компани нь:	Үгүй	Тийм
а. Усны чанарын мэдээллийг хэмжилт хийгдсэн газар тус бүрээр нь тогтмол мэдээлдэг эсэх?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
б. Усны чанар хаана, хэзээ аюулгүй байдлын зөвшөөрсөн хэмжээнээс доогуур түвшинд хүрсэн талаар онцгойлон мэдээлдэг эсэх?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
в. Усны чанартай холбоотой явуулах үйл ажиллагааны шийдвэр гаргах явцдаа уурхайн нөлөөлөлд өртөж буй орон нутгийн иргэдийг оролцуулдаг эсэх?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
г. Усны чанарын талаарх шийдвэр гаргах явцдаа уурхайн нөлөөллөлд өртөж буй орон нутгийн эмэгтэйчүүдийг идэвхтэй оролцуулдаг эсэх?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

05 Усны Хэмжээ		
Энэ уурхайг ажиллуулахдаа компани нь:	Үгүй	Тийм
а. Уурхайн үйл ажиллагаанд ашиглахаар газрын гадарга болон газрын гүнээс татан хэрэглэсэн усны хэмжээгээ олон нийтэд тогтмол мэдээлдэг эсэх?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
б. Гадаргын болон гүний усны эх үүсвэрийг уурхай болон орон нутгийн иргэд хэрхэн хамтран ашиглах зохицуулалтын талаар тухайн уурхайн нөлөөлөлд өртөж буй орон нутгийн иргэдтэй зөвлөлддөг эсэх?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
в. Гадаргын болон гүний усны эх үүсвэрийг уурхай болон орон нутгийн иргэд хэрхэн хамтран ашиглах зохицуулалтын талаар зөвлөлдөхдөө эмэгтэйчүүдийг идэвхтэй оролцуулдаг эсэх?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
г. Уурхайн ус ашиглалтыг бууруулахаар авах арга хэмжээтэй холбоотой шийдвэр гаргах явцдаа уурхайн нөлөөлөлд өртөж буй орон нутгийн иргэдийг оролцуулдаг эсэх?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

**06 Уурхайн Нөхөн Сэргээлт болон Хаалтын Дараах Төлөвлөгөө**

Энэ уурхайг ажиллуулахдаа компани нь:		Үгүй	Тийм
а.	Уурхайн үйл ажиллагаа хэзээ зогсож, бүрмөсөн хаагдахыг тухайн уурхайн нөлөөлөлд өртөж буй иргэдэд мэдэгдсэн эсэх?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
б.	Уурхайн нөхөн сэргээлт болон хаалтын төлөвлөгөөг боловсруулахдаа уурхайн нөлөөлөлд өртөж буй орон нутгийн иргэдтэй харилцаж санал хүсэлтийг нь тусгасан эсэх?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
в.	Уурхайн нөхөн сэргээлт болон хаалтын төлөвлөгөөг уурхайн нөлөөлөлд өртөж орон нутгийн иргэд зөвшөөрсөн эсэх?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
г.	Уурхайн нөхөн сэргээлт болон хаалтын төлөвлөгөө боловсруулах болон түүнийг баталгаажуулах явцдаа уурхайн нөлөөлөлд өртөж буй эмэгтэйчүүдийг идэвхтэй оролцуулдаг эсэх?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

07 Уурхайн Хаягдлын Далан/Сан Түүний Хяналт Зохицуулалт

Энэ уурхайг ажиллуулахдаа компани нь:		Үгүй	Тийм
а.	Хаягдлын далан/сангийн тодорхой байршлыг олон нийтэд мэдээлдэг эсэх?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
б.	Хаягдлын далан/сангийнхаа аюулгүй байдлыг ханган тэмдэг тэмдэглэгээг байршуулан , хүн малын осол эндэгдлээс сэргийлэх арга хэмжээ авсан эсэх?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
в.	Хаягдлын далан/сан эвдэрсэн тохиолдолд түүнээс үүдэн сөрөг нөлөөлөлд нь өртөж болзошгүй орон нутгийн газар зүйн байршлыг тогтоон олон нийтэд мэдээлдэг эсэх?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
г.	Хаягдлын далан/сан эвдэрч нурах гэх мэт онцгой тохиолдолд уурхайн нөлөөлөлд өртөж буй иргэд болон ажилчдад гамшгийг зарлан мэдээлэх дуут дохиолол болон аюулаас хамгаалах бусад арга нэвтрүүлэн тэдгээрийн хэвийн ажиллагааг тогтмол туршдаг эсэх?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>



08 Орон Нутгийн Иргэдийн Аюулгүй Байдал		
Энэ уурхайг ажиллуулахдаа компани нь:	Үгүй	Тийм
а. Уурхайн талбарын лицензтэй талбай, түүний орчим гарсан хүний амь нас эрдсэн тохиолдол, шалтгаан, нөхцөл байдлын талаар олон нийтэд ил тод мэдээлдэг эсэх?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
б. Уурхайн талбар үйл ажиллагаанаас нь үүдэлтэй гэнэтийн осол, гамшгийн үед орон нутгийн иргэд аюулгүй байдлаа хангахын тулд хийх хэрэгтэй алхмуудыг тэдэнд танилцуулсан эсэх?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
в. Уурхайн гэнэтийн осол гамшгийн үеийн төлөвлөгөөг турших, дадлага сургууль хийхдээ орон нутгийн иргэдийг оролцуулдаг эсэх?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
г. Уурхайн гэнэтийн осол гамшгийн үеийн төлөвлөгөөг турших, дадлага сургууль хийхдээ уурхайн нөлөөлөлд өртөж буй орон нутгийн эмэгтэйчүүдийг идэвхтэй оролцуулдаг эсэх?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

09 Орон Нутгийн Иргэдийн Гомдол Хүлээн Авч Барагдуулах Механизм		
Энэ уурхайг ажиллуулахдаа компани нь:	Үгүй	Тийм
а. Уурхайн талбарын үйл ажиллагааны хүрээнд орон нутгийн иргэд болон хувь хүн гомдол санал гаргах түүнийг нь хүлээн авч аливаа зөрчлийг зохих ёсоор залруулах тусгай механизм ажиллуулдаг эсэх?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
б. Гаргасан гомдол саналыг хүлээн авч шийдвэрлэдэг ажилтнууд нь эмэгтэй болон эрэгтэй ажилтны аль аль нь байх бөгөөд, тухайн гомдол гаргагч эмэгтэй хүссэн тохиолдолд өөрийн хүйсийн ажилтантай харилцах боломжоор хангасан эсэх?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
в. Уурхайн нөлөөлөлд өртөж буй орон нутгийн иргэд, хувь хүнээс ирүүлсэн гомдол саналын тоо болон тэдгээрийн төрөл, агуулгын талаар олон нийтэд нээлттэй ил тод мэдээлдэг эсэх?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
г. Олон давтамжтай ирүүлж буй гомдол санал дахин давтагдахаас сэргийлэх арга хэмжээнийхээ талаар орон нутгийн иргэдтэй зөвлөлддөг эсэх?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>



10 Хөдөлмөрийн Аюулгүй Байдал ба Эрүүл Мэнд		
	Үгүй	Тийм
Энэ уурхайг ажиллуулахдаа компани нь:		
а.	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
Уурхайн талбарт ажиллаж буй компанийн өөрийн болон туслан гүйцэтгэгч, гэрээт компаниудын бүх ажилчдад зохих ёсны хөдөлмөр хамгааллын хэрэгслээр үнэ төлбөргүй хангасан эсэх?		
б.	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
Уурхайн талбарт ажиллаж буй компанийн өөрийн болон туслан гүйцэтгэгч, гэрээт компаниудын ажилчдад эрүүл ахуйн шаардлага хангасан ариун цэврийн өрөө , халуун усны газар, хувцас солих өрөө зэргээр хангасан эсэх?		
в.	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
Эмэгтэй ажилчдад зориулсан, тэдний аюулгүй байдлыг нь хангахуйц зохих ёсны ариун цэврийн өрөө , халуун усны газар, хувцас солих өрөө зэргээр хангаж эрэгтэй ажилчдынхаас тусад нь байршуулсан эсэх?		
г.	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
Уурхайн талбарын ажилчин тус бүрийн тухайн өдөрт ажилласан дундаж ажлын цагийг тооцож ил тод мэдээлдэг эсэх?		

11 Эмэгтэй Ажилчид		
	Үгүй	Тийм
Энэ уурхайг ажиллуулахдаа компани нь:		
а.	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
Уурхайн талбар дахь эмэгтэй ажилчдын эсрэг аливаа хүчирхийллээс сэргийлэх арга хэмжээ авсан эсэх?		
б.	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
Уурхайн талбар дахь эмэгтэй ажилчдын эсрэг аливаа жендерт суурилсан хүчирхийлэл доромжлол гарахаас сэргийлэх арга хэмжээ авсан эсэх?		
в.	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
Уурхайн талбар дахь компанийн өөрийн болон туслан гүйцэтгэгч, гэрээт компаниудын эмэгтэй ажилчдад зориулан эмэгтэй хүний биеийн онцлогт нийцсэн хөдөлмөр хамгааллын хэрэгслээр хангасан эсэх?		
г.	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
Хүйсийн тэгш байдал, жендерийн талаарх мэдлэг ойлголт таниулах сургалтыг компанийн өөрийн болон туслан гүйцэтгэгч, гэрээт компаниудын ажилчдад зориулан зохион байгуулдаг эсэх?		



12 Ажлын байр дахь Үйлдвэрлэлийн Осол Эндэгдэл		
Энэ уурхайг ажиллуулахдаа компани нь:	Үгүй	Тийм
Уурхайн талбарт бэртэл гэмтэл авсан болон нас барсан ажилчдын тоо, ослын шалтгаан нөхцөл байдлын талаар олон нийтэд ил тод мэдээлдэг эсэх?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
Уурхайн талбарт бэртэл гэмтэл авсан болон нас барсан туслан гүйцэтгэгч, гэрээт компаниудын ажилчдын тоо, ослын шалтгаан нөхцөл байдлын талаар олон нийтэд ил тод мэдээлдэг эсэх?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
Уурхайн талбар дахь ажилчид болон ажил олгогч нарын төлөөллөөс бүрдсэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хамтарсан зөвлөл байгуулан эрсдэлийн үнэлгээ хийх болон гарсан үйлдвэрлэлийн осол эндэгдлийг мөрдөн шалгадаг эсэх?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хамтарсан зөвлөлд эмэгтэй ажилчдын төлөөллийг хамруулсан эсэх?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

13 Ажилчдын Сургалт		
Энэ уурхайг ажиллуулахдаа компани нь:	Үгүй	Тийм
Компани өөрийн болон туслан гүйцэтгэгч, гэрээт компаниудын бүх ажилчдад осол эндэгдэлгүй ажиллахад шаардагдах зааварчилгааг танилцуулдаг эсэх?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
Уурхайн талбар дахь ажилчдаа техникийн мэдлэг чадвар олгох сургалтад үнэ төлбөргүй хамруулдаг эсэх?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
Ажилчдад зориулан зохион байгуулж буй бүх сургалтууд болон бусад хөгжлийн хөтөлбөрүүддээ эмэгтэйчүүдийн оролцоог хангадаг эсэх?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
Уурхайн гэнэтийн осол гамшгийн үеийн төлөвлөгөөг турших, дадлага сургууль хийхдээ бүх ажилчид үүнд гэрээт, туслан гүйцэтгэгч компаниудын ажилчдыг хамруулдаг эсэх?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>



14 Амьдралын Баталгааг Хангаж Чадахуйц Цалин Хөлс		
Энэ уурхайг ажиллуулахдаа компани нь:	Үгүй	Тийм
а. Уурхайн талбар дахь ажилчид болон тэдгээрийн гэр бүлийн амьдралын баталгаат түвшинд шаардлагатай цалин хөлсний хэмжээг үнэлэн тогтоодог уу?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
б. Компани өөрийн ажилчдын цалин хөлсийг тус үнэлгээнээс тогтоосон амьдралын баталгааг хангахуйц эсвэл түүнээс илүү гарсан цалин хөлсний хэмжээнд нийцүүлэн олгодог эсэх?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
в. Уурхайн талбар дахь туслан гүйцэтгэгч, гэрээт компаниудын ажилчдын цалин хөлс тус үнэлгээнээс тогтоосон амьдралын баталгааг хангахуйц эсвэл түүнээс илүү гарсан цалин хөлсний хэмжээнд нийцдэг эсэх?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
г. Ажлын байр бүрд эмэгтэй эрэгтэй ажилчдын авч буй цалингийн хамгийн доод хэмжээг ил тод мэдээлдэг эсэх?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

15 Ажилчдын Гомдол Хүлээн Авч Барагдуулах Механизм		
Энэ уурхайг ажиллуулахдаа компани нь:	Үгүй	Тийм
а. Компани өөрийн болон туслан гүйцэтгэгч, гэрээт компаниудын ажилчдын аль алинд нь зориулсан гомдол санал гаргах түүнийг нь хүлээн авч барагдуулах тусгай механизмтай эсэх?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
б. Гаргасан гомдол саналыг хүлээн авч шийдвэрлэх ажилтнууд нь эмэгтэй болон эрэгтэй ажилтны аль аль нь байх бөгөөд, тухайн гомдол гаргагч эмэгтэй хүссэн тохиолдолд өөрийн хүйсийн ажилтантай харилцах боломжоор хангасан эсэх?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
в. Компани өөрийн болон туслан гүйцэтгэгч, гэрээт компаниудын ажилчдаас ирүүлсэн гомдол саналын тоо болон тэдгээрийн агуулгын талаар олон нийтэд ил тод мэдээлдэг эсэх?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
г. Олон давтамжтай ирүүлж буй гомдол санал дахин давтагдахаас сэргийлэх арга хэмжээнийхээ талаар уурхайн талбар дахь өөрийн болон туслан гүйцэтгэгч, гэрээт компаниудын ажилчдын төлөөлөл/үйлдвэрчний эвлэлтэй зөвлөлддөг эсэх?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>



Тэмдэглэл:



Тайлбар

01 Орон Нутгийн Ажил Эрхлэлт

Компани орон нутгаас элсүүлсэн ажилчдын тоогоо олон нийтэд нээлттэй мэдээлэх нь тухайн орон нутгийн иргэдийг ажлын байраар хангах замаар эдийн засагт нь хувь нэмэр оруулах үүрэг амлалтаа хэрхэн биелүүлж буйгаа батлан харуулах боломж олгодог. Мөн эмэгтэй ажилчдын талаарх мэдээллээ ил тод болгосноор компанийн хүний нөөцийн бодлого, боломж нь эмэгтэйчүүдэд адил тэгш үйлчилж буй эсэхийг хянах боломж олгодог. Түүнчлэн уурхайн ажил эрхлэлтийн байдлыг бүрэн дүгнэхэд туслан гүйцэтгэгч, гэрээт компаниудынхаа орон нутгаас элсүүлсэн ажилчдын тоог мэдээлэх нь чухал юм.

02 Орон Нутгийн Худалдан Авалт

Аливаа бүтээгдэхүүн үйлчилгээг орон нутгийн ханган нийлүүлэгчдээс худалдан авах нь тухайн орон нутгийн бизнес эрхлэлт болон эдийн засгийн хөгжилд чухал хувь нэмэр оруулдаг. Орон нутгийн худалдан авалтын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг олон нийтэд ил тод болгох нь орон нутгийн бизнес эрхлэгчид ханган нийлүүлэлтийн боломжийг нээх, тухайн нутгийн иргэд, дотоодын бизнес эрхлэгчдэд уурхайд нийлүүлэлт хийхэд хэрхэн дэмжлэг үзүүлж буйгаа харуулах боломж олгодог.

03 Агаарын Чанар

Уурхайн үйл ажиллагааны нөлөөллийн бүсэд орших иргэдийн хувьд агаарын чанар ямагт тулгамдсан асуудал байдаг бөгөөд тэдний эрүүл мэнд, хоол хүнс болон бэлчээрийн мал, ургац тариа зэрэг амьжиргааны хэрэгсэлд нь нөлөөлж байдаг. Уурхайн ойр орчмын агаарын чанарыг хэмжин олон нийтэд тогтмол мэдээлэх, түүнчлэн агаарын чанарын талаар компаниас авч буй арга хэмжээний талаар нутгийн иргэдтэй зөвлөлдөх нь агаарын бохирдол болон тоос шорооноос үүдэлтэй үл ойлголцол, айдас түгшүүрийг багасгах ач холбогдолтой.

04 Усны Чанар

Компаниуд уурхай орчмын усны чанарын үзүүлэлтийн мэдээллийг уурхайн нөлөөлөлд өртөж буй иргэд ойлгож ашиглахуйц байдлаар, чанарын хэмжилт хийгдсэн газар тус бүрээр нь харуулах шаардлагатай. Түүнчлэн усны чанар хаана, хэзээ зөвшөөрөгдсөн хэмжээнээс доогуур төвшинд хүрсэн талаар мэдээлэх, мөн усны чанарын талаар авч буй арга хэмжээнийхээ талаар орон нутгийн иргэдтэй зөвлөлдсөнөөр иргэд компани хоорондын итгэлцлийг бий болгодог.

05 Усны Хэмжээ

Усны хангамж нөөцийн асуудал нь уурхайн нөлөөлөлд өртөж буй иргэд болон компани хоорондын зөрчилдөөнийг үүсгэдэг бөгөөд энэ нь усны нөөц багатай газарт түгээмэл тохиолддог. Компани уурхайн үйл ажиллагаанд зориулан орон нутгийн усны ундаргаас татан хэрэглэсэн усны хэмжээгээ ил тод мэдээлэх болон уурхайн усны хэрэглээг зохицуулахдаа орон нутгийн усны хэрэгцээг хэрхэн харгалзан үзэх талаараа уурхайн нөлөөлөлд өртөж буй иргэдтэй хэлэлцэх нь тэдний эрхийг хүндэтгэж буй явдал юм.



06 Уурхайн Нөхөн Сэргээлт болон Хаалтын Дараах Төлөвлөгөө

Уурхайн үйл ажиллагаа явуулсан газартаа эерэг нөлөөлөл үлдээхийн тулд уурхайн хаагдсаны дараа орон нутгийн иргэд амьжиргааны тогтвортой хэрэгслээр хангагдсан байх шаардлагатай. Үүнд, байгалийн нөөц баялаг буюу газар, бэлчээрийн талбай, ус зэргийг эрүүл аюулгүй хэмжээнд хадгалах болон буцаан нөхөн сэргээх, мөн эдийн засгийн боломжийг бууруулахгүй байх зэрэг орно. Уурхайн хаалтын төлөвлөгөө боловсруулах, түүнийг батлахдаа орон нутгийн иргэдтэй зөвлөлдөн уурхай хаагдсаны дараа тухайн газар нутгийн төлөв байдлын талаарх санал хүсэлтийг харгалзан үзэх шаардлагатай.

07 Уурхайн Хаягдлын Далан/Сан Түүний Хяналт Зохицуулалт

Уурхайн үйл ажиллагааны явцад буюу түүхий эд олборлох, боловсруулах үед ялгарсан шороо чулуулгын овоолго болон хаягдал усны далан/сан нь хүн, мал амьтан, байгаль орчинд их хэмжээний аюул эрсдэл учруулах өндөр магадлалтай байдаг. Хэрвээ тухайн хаягдлын далан/сан эвдэрсэн тохиолдолд түүнээс гарах овоолгоос үүдсэн их хэмжээний бохирдол хөрс, гол усанд нэвчих, хүний амь нас хохироох, байшин барилга нураах, бэлчээр, мал аж ахуй болон бусад амьжиргааны эх үүсвэрийг алдагдуулж байгаль орчин, орон нутгийн иргэдэд олон жил үргэлжлэх үлэмж хэмжээний хохирол учруулах үр дагавартай. Иймд компани уг асуудлыг чухалчлан авч үзэх, хаягдал ус, шороо чулуулгийн овоолго бүхий далан/сангийн талаарх бодит мэдээллээр хангах, аюулгүй байдлын тэмдэг тэмдэглэгээг байршуулан хүн малын осол эндэгдлээс сэргийлэх бүхий л арга хэмжээг авах ёстой. Түүнчлэн аюул гамшгийн тухай зарлан мэдээлэх дуут дохиолол, анхааруулах бусад арга нэвтрүүлэн гамшгаас хамгаалах дадлага сургалт тогтмол зохион байгуулах шаардлагатай.

08 Орон Нутгийн Иргэдийн Аюулгүй Байдал

Уул уурхайн үйл ажиллагаа нь орон нутгийн иргэдийн аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлэх тохиолдол түгээмэл байдаг бөгөөд аливаа осол эндэгдэл, маргаан зөрчилдөөн нь бэртэл гэмтэл болон хүний амь насанд аюул учруулах эрсдэлтэй. Компани уурхайтай холбоотойгоор хүний амь эрсэдсэн тохиолдол, түүнийг үүсгэсэн хүчин зүйл ба нөхцөл байдлын талаар мэдээлэх нь уурхай орчмын нутгийн иргэдийн аюулгүй байдал эрсдэлд орохоос сэргийлэх боломжтой. Уул уурхайн үйл ажиллагаатай холбогдон гардаг аливаа гэнэтийн аюул ослоос бүрэн сэргийлэх боломжгүй ч компаниуд гамшгийн менежмент болон гэнэтийн ослын бэлэн байдалд зориулсан төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлснээр эрсдэл, гарч болох сөрөг үр дагаврыг бууруулах боломжтой. Үүнээс гадна гаргасан гамшгийн төлөвлөгөө болон гэнэтийн ослын үед авах шаардлагатай арга хэмжээгээ уурхайн нөлөөлөлд өртөж буй орон нутгийн иргэдэд танилцуулах, мөн гамшгаас хамгаалах хамтарсан дадлага сургууль хийх нь компани тухайн төлөвлөгөөг бодит байдалд үр дүнтэй хэрэгжүүлэх алхам болдог.



09 Орон Нутгийн Иргэдийн Гомдол Хүлээн Авч Барагдуулах Механизм

Орон нутгийг иргэдийг хүндэтгэн хариуцлагатай үйл ажиллагаа явуулдаг компани тэдний санал хүсэлт, тулгамдаж буй асуудлуудын талаар мэдэх, улмаар шаардлагатай хариу арга хэмжээ авах нь зүйтэй юм. Үүнийг хэрэгжүүлэх нэг арга нь хувь хүн болон бүлэг хүмүүсээс уурхайн үйл ажиллагаатай холбоотой аливаа сөрөг нөлөөллийг мэдээлэх, учирсан хохирол, гомдлоо компаниар барагдуулах бололцоо олгодог албан ёсны процесс бий болгох юм. Тухайн механизмыг хэрхэн ашиглах, гарч буй гомдол саналыг хэрхэн шийдвэрлэсэн талаарх мэдээллийг олон нийтэд ил тод болгох нь орон нутгийн иргэдийн тус механизмд итгэх итгэлийг бэхжүүлж улмаар ашиглалтыг нэмэгдүүлдэг.

10 Хөдөлмөрийн Аюулгүй Байдал ба Эрүүл Мэнд

Ажлын байр дахь хөдөлмөрийн аюулгүй байдал нь ажилчдын бие махбодын болон сэтгэцийн эрүүл мэндэд нөлөөлж байдаг бөгөөд ажлын байрны бүтээмжийг нэмэгдүүлэн ажилчид төдийгүй хөрөнгө оруулагчдыг татах чухал үзүүлэлт болдог. Уул уурхайн компаниуд хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл мэндийн эрсдэлийг бууруулах болон сэргийлэхэд эмэгтэй болон эрэгтэй ажилчдын аль алинд нь тохирсон зохих ёсны хөдөлмөр хамгааллын хэрэгслээр бүрэн хангах, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн ажлын байр, ариун цэврийн өрөө, бусад шаардлагатай хэрэгслээр хангасан байх хэрэгтэй. Түүнчлэн ажлын цаг, хуваарийг ил тодоор хянах нь зүй бус практик буюу олон цагаар хэтрүүлэн ажиллуулах болзошгүй эрсдэлээс сэргийлдэг.

11 Эмэгтэй Ажилчид

Уурхайн талбар дахь ажиллах орчин, хөдөлмөрийн нөхцөл нь эмэгтэй ажилчдад ээлтэй бус тэднийг илүү эрсдэлд оруулах нь түгээмэл бөгөөд тэдний нөхцөл байдал ч эрэгтэй ажилчидтай харьцуулбал илүү эмзэг байдаг. Компани нь эмэгтэй ажилчдын тус онцлогийг харгалзан хүндэтгэх, аливаа хүчирхийлэл, жендерт суурилсан доромжлол, заналхийллээс сэргийлэн хамгаалах болон эмэгтэй хүн хэрэглэхэд зохистой хөдөлмөр хамгааллын хэрэгслээр хангах шаардлагатай.

12 Ажлын байр дахь Үйлдвэрлэлийн Осол Эндэгдэл

Уул уурхайн үйл ажиллагаа нь аюултай ажил мэргэжилд тооцогддог бөгөөд уурхайн талбарт үйлдвэрийн ослын улмаас хүний амь эрстэх тохиолдол түгээмэл хэвээр байна. Иймд уул уурхайн компаниуд хөдөлмөрийн аюулгүй байдлын эрсдэлийг бууруулах, сэргийлэх арга хэмжээ авахаас гадна бэртэл гэмтэл, амь насаа алдсан осол аваар зэргийг мөрдөн шалгаж олон нийтэд ил тод мэдээлэх шаардлагатай. Уул уурхайн салбарт туслан гүйцэтгэгч, гэрээт компаниар ажил гүйцэтгүүлэх явдал түгээмэл байдаг учир тухайн уурхайн талбар дахь туслан гүйцэтгэгч, гэрээт компаниудын ажилчдын амь нас эрстсэн осол эндэгдлийн талаарх мэдээллийг мөн адил ил тод болгох нь тухайн компанийн хөдөлмөрийн нөхцөлийг бүрэн дүгнэх боломж олгодог.



13 Ажилчдын Сургалт

Дэлхийн Хөдөлмөрийн Байгууллагаас гаргасан зөвлөмжийн дагуу уурхайн талбарт ажиллах ажилтан нь хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг ханган ажиллахад шаардлагатай сургалт мэдээллээр хангагдсан байх ёстой. Сургалт нь эрүүл аюулгүй ажиллагааны сэдвээр хязгаарлагдахгүй бөгөөд техникийн мэдлэг чадвар олгох сургалт зохион байгуулах шаардлагатай. Ажилчдыг сурган боловсруулах нь тэдний хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх давуу талтай.

14 Амьдралын Баталгааг Хангаж Чадахуйц Цалин Хөлс

Амьдралын баталгаат түвшинд хүрэхүйц цалин хөлс нь ажилчид болон тэдний гэр бүл ядуурлын түвшнээс дээгүүр амьдрах баталгаа болж, амьдралын суурь хэрэгцээгээ хангахаас гадна нийгэм соёлын амьдралд идэвхтэй оролцох боломж олгодог. Амьдралын баталгаат түвшинд хүрэхүйц цалин хөлс авах нь хүний суурь эрхийн нэг юм. Компани өөрийн болон туслан гүйцэтгэгч, гэрээт компаниудынхаа ажилчдад амьдралын баталгаат түвшинд хүрэхүйц цалин хөлс олгох алхам хийх нь ажилчдын эрхийг хүндэтгэх үүргээ биелүүлж буй хэрэг ба ингэснээр тэдэнтэй харилцаагаа бэхжүүлж, ёс зүй ажлын бүтээмжийг нь нэмэгдүүлдэг.

15 Ажилчдын Гомдол Хүлээн Авч Барагдуулах Механизм

Ажилчдаа хүндэтгэж буй компани тэдний санал хүсэлт, тулгамдаж буй асуудлуудын талаар мэдэх, шаардлагатай хариу арга хэмжээ авах нь зүйтэй. Үүнийг хэрэгжүүлэх нэг арга нь ажилчид аливаа гомдол, санал хүсэлтээ мэдүүлэх, гарсан зөрчил хохирлоо компаниар барагдуулах бололцоо олгодог албан ёсны процесс бий болгох юм. Санал гомдол хүлээн авч шийдвэрлэх үр дүнтэй механизм нь ажилтан ажил олгогч нарын харилцаанд эерэг нөлөө үзүүлдэг. Тухайн механизмыг хэрхэн ашиглах, гарч буй гомдол саналыг хэрхэн шийдвэрлэсэн талаарх мэдээллийг ажилчдад ил тод болгох нь тэдний тус механизмд итгэх итгэлийг бэхжүүлж ашиглалтыг нэмэгдүүлдэг.

Хариуцлагатай уул уурхайн талаарх бүрэн хэмжээний арга зүйтэй танилцахыг хүсвэл Хариуцлагатай Уул Уурхайн Сангийн цахим хаягт хандана уу:

www.responsibleminingfoundation.org

Асуулт болон тусламж хэрэгтэй бол доорх и-мэйл хаягаар холбогдоно уу:

contact@responsibleminingfoundation.org

Тэмдэглэл

Энэхүү баримт бичигт тусгагдсан санаа, агуулга, дүгнэлт, тайлбарууд нь Хариуцлагатай Уул Уурхайн Сангийн ажилчид, санг санхүүжүүлэгчид, ивээн тэтгэгч байгууллагууд болон тус баримт бичгийг батлах хэлэлцүүлэгт оролцсон болон зөвлөсөн этгээдүүдийн байр суурийг илэрхийлээгүй болно

Олон нийтэд зориулан үнэ төлбөргүй хэвлэв



Бүх мэдээлэл, өгөгдлүүд болон бичгэн контент нь Creative Commons Attribution-NonCommercial 4.0 International License (CC BY-NC 4.0) дагуу хамгаалагдсан. Хэрэглэгчид нь энэхүү баримт бичгийг бусдад, түгээх, хэрэгцээндээ тохируулан өөрчлөх эрхтэй боловч зохих ёсоор ишлэл авч, хэрэв өөрчлөгдсөн тохиолдолд дээрх зөвшөөрлийн цахим хуудсыг багтаах ёстой. Энэхүү баримт бичгийг худалдааны зорилгоор болон аливаа ялгаварлан гадуурхал, доромжлол, гүтгэлэг хийх зорилгоор ашиглах ёсгүй. Ишлэх тохиолдолд: Хариуцлагатай Уул Уурхайн Сан (2020), Уурхайн Талбарын Үнэлгээний Хэрэгсэл (хувилбар 3) гэх.

